

Тендерийн урилга

Огноо: **2023 оны 6 дугаар сарын 9-ний өдөр**
Зээлийн дугаар ба нэр: **Зээл 3843/3844-MON: Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр – I үе шат**
Гэрээний дугаар ба нэр: **БА04: Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв (3)-ийн барилгын ажил**

1. Монгол улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” I үе шат төслийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээний төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.
2. Эрүүл мэндийн яам (“Захиалагч”) нь эрх бүхий тендерт оролцогчийг **БА04: Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв (3)-ийн барилгын (“Ажил гэх”) ажлыг** хийж гүйцэтгэх, дуусгах тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.
3. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (дотоодод зарлан мэдээлэх)-ыг АХБ-ны **нэг үе шаттай: нэг дугтуйт** горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.
4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:
 - **Санхүүгийн үзүүлэлт:**
Тендерт оролцогчийн одоогийн санхүүгийн чадавхийг харуулах үүднээс сүүлийн 3 жилийн (2020, 2021, 2022) аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, эсхүл тендерт оролцогчийн харьяа орны хуулиар аудитаар баталгаажуулахыг үл шаардсан бол захиалагчийн зөвшөөрөх бусад хэлбэрийн санхүүгийн тайланг илгээнэ. Тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн доод хэмжээг нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцох ба энэ зөрүү нь ашигтай байна.
 - **Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт:**
Сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) хэрэгжиж байгаа эсхүл хэрэгжиж дууссан гэрээт ажлын хүрээнд хийгдсэн нийт баталгаат төлбөрийн дүнгээр тооцож гаргасан барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ **3 тэрбум** төгрөг байна.
 - **Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага:**
Тендерт оролцогч нь одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр **511 сая** төгрөгийн санхүүгийн чадварын шаардлагыг хангах хүрэлцээтэй санхүүгийн нөөц хөрөнгөтэй байх.
 - **Төрөл ба хэмжээгээр төстэй гэрээний туршлага:**
Сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь **2.3 тэрбум** төгрөгөөс доошгүй байх.

- **Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлага:**

- (i) 850 мкв-аас багагүй талбай бүхий цутгамал төмөр бетон хийцлэлтэй барилга барьж байсан туршлагатай байх;
- (ii) Хамгийн багадаа 200 мкв авто замын сүлжээ барьж байсан туршлагатай байх;
- (iii) Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээний халдваргүй, ариун орчныг бүрдүүлэхүйц өрөө, тасалгааны шинэчлэл засвар үйлчилгээ хийж байсан туршлагатай байх. Үүнд: дүрс оношилгоо, мэс засал, эрчимт эмчилгээ, яаралтай тусламж болон бусад

5. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцах сонирхолтой эрх бүхий тендер оролцогч нь дараах хаягаар хандана:

Захиалагч	:	Эрүүл мэндийн яам
Харилцах ажилтан	:	А.Юмчмаа, “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” I үе шат, Төслийн ХАА-ны ажилтан
Хаяг	:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байрны өргөтгөл, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байр, 3 давхар, 304 тоот, 976-11-329369
Цахим шуудангийн хаяг	:	procurement2@hsdp.org

6. Монгол хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг авах хүсэлтэй тендер оролцогч нь дор дурдсан хаягт хандан энэ тухай албан хүсэлт гаргаж, үл буцаан олгох нөхцөлөөр **350,000.00** (гурван зуун тавин мянга) төгрөгийн төлбөрийг хийнэ. Төлбөрийн нөхцөл нь доорх дансаар дамжуулан шилжүүлсэн байна.

<u>Гадаад шилжүүлэг</u>		<u>Дотоод шилжүүлэг</u>	
Payee's Name	: Improving Access to Health Services for Disadvantaged Groups Investment Program	Дансны нэр	: ЭБИЭМТҮХСХОХ МОН3843
Bank Name	: State Bank of Mongolia Ulaanbaatar, Mongolia	Банкны нэр	: Төрийн сан
Payee's Account No.	: 106000076051 (USD)	Дансны дугаар	: 100900011878 (MNT)
SWIFT Code	: STBMMNUB		
Corresponding Bank			
Bank Name	: Kookmin Bank		
SWIFT Code	: CZNBKRSE		
Account No.	: 7968USD019		

7. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа **2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 15 цаг 00 минутаас (Улаанбаатарын цагаар)** өмнө Монгол улс Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байрны өргөтгөл, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байр, 2 давхар, 203 тоот өрөөнд тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусмагц тендерийг нэн даруй нээх ба тендер оролцогчдын төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр байлцуулна.

8. Захиалагч нь тендер оролцогчийн тендер бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдсон аливаа зардлыг хариуцахгүй.